



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
<http://www.parliament.mn>


2026.05.26 № УИХ-01/6036  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Улсын Их Хурлын гишүүдийн асуулт хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдааны Улсын Их Хурлын асуулгын цагаар Ерөнхий сайдад тавих Улсын Их Хурлын гишүүдийн асуултыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2-т "Гишүүд Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлэх бөгөөд ирүүлсэн асуултыг нэгтгэн Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдад ажлын 2 өдрийн дотор хүргүүлж, асуултыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулна." гэж заасны дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт <sup>8</sup>... хуудастай.

ДАРГА



С.БЯМБАЦОГТ

2026000173

Монгол Улсын Их Хурлын 2026 оны  
05 дугаар сарын 29-ны өдрийн УИХ/01/0038  
дугаар албан бичгийн хавсралт

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
05 дугаар сарын 29-ний өдрийн Баасан гарагийн нэгдсэн хуралдааны  
Улсын Их Хурлын асуулгын цагт Ерөнхий сайдаас асуухаар ирүүлсэн  
Улсын Их Хурлын гишүүдийн асуулт**

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ</b>		
1	О.Цогтгэрэл	Сэдэв: Данхар төр - Дарамтат татвар <ul style="list-style-type: none"><li>Данхар төр - Дарамтат татвар?</li></ul>
2	Ц.Баатархүү	Сэдэв: Данхар төр - Дарамтат татвар 2025 оны байдлаар төрийн 4330 байгууллагад 213,611 төрийн албан хаагч ажиллаж байна. МАН 2016-2020 онд 9 төрлийн татварыг нэмснээр төсвийн орлого тал 2 дахин нэмэгдсэн. Төсөвт эзлэх иргэдийн татварыг нэмж, төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлснээр төрийн бүтээмж сүүлийн 10 жилд хэдэн хувиар өссөн бэ? Төсвийн орлого бүтээмжийн харьцаа өнөөдөр хэд байна вэ?
3	Д.Батбаяр	Сэдэв: Данхар төр - Дарамтат татвар 1.Татварын өсөлтийн талаар мэдээлэл, 2.Төрийн албан хаагчдын орон тооны өсөлт, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг өгнө үү?
4	Г.Ганбаатар	Сэдэв: Данхар төр - Дарамтат татвар 1.2016 оноос хойших нийт төрийн хаагчдын тооны өсөлт, төрийн албан хаагчдад холбогдох төсвийн орлого, зарлага 2.2016 оноос хойших татварын өөрчлөлтийн талаар мэдээлэл өгнө үү?
5	С.Ганбаатар	1.Газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгуулахад ихээхэн хэмжээний дотоодын зээл авсан мэдээ байгаа. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1.7 тэрбум америк долларын зээлээс хэчнээн долларыг энэ төсөлд зарцуулаад байна вэ? Эдгээр дотоод, гадаадын зээл, зээлийн хүү нь төсөв ба татварт ямар хэмжээний дарамт ачаалал үүсгэж байна вэ?
6	Г.Очирбат	Сэдэв: Данхар төр - Дарамтат татвар Та данхар төр, татварын дарамтаас гарах ямар шийдэл, шийдвэр гарган ажиллах вэ?
7	Г.Хосбаяр	Сэдэв: Данхар төр - Дарамтат татвар - Уул уурхай, барилга, үйлчилгээ, хөдөө аж ахуй гэх мэт

		салбарууд өөр өөр татварын хувь хэмжээтэй байж болох уу?
8	Д.Цогтбаатар	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг хэрхэн үр ашигтай хийж, хэзээ баялгийн тэгш хуваарилалтын бодит эерэг нөлөө ард иргэдийн амьдралд мэдрэгдэх вэ?</li> </ul>
9	Ө.Шижир	<p>Нэг.Төсвөөс гадуур төсвийн тухай</p> <p>Монгол Улсын Их Хурлаас жил бүрийн төсвийг баталдаг боловч уг төсөв нь жилээс жилд өсөж данхайсаар төсвийн 75 орчим хувь нь зөвхөн урсгал зардлыг санхүүжүүлж байна.</p> <p>Нөгөөтэйгүүр Улсын нэгдсэн төсөвт тусгахгүйгээр төрийн өмчийн гэх аж ахуйн нэгжүүдийн худалдан авалт, зардал хэрээс хэтэрсэн.</p> <p>Төрийн өмчийн байгууллагуудын нийт зардал нь улсын нэгдсэн төсөвтэй дүйж ирж байгаа нь төрийн хэт данхар бүтэц, төсвийн замбараагүй зарцуулалт хэрээс хэтэрснийг илтгэж байгаа ба үүний цаана албан тушаал, авлигын томоохон эх үүсвэр байгаа гэдэгт итгэлтэй байна.</p> <p>Төсвөөс гадуурх төрийн өмчийн байгууллагын зардлыг бууруулах, бүтцийг цөөлөх, хувийн хэвшлээр ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх зэрэг аливаа арга хэмжээ төлөвлөж байгаа юу? Тийм бол Улсын Их Хуралд танилцуулна уу?</p> <p>Хоёр.Татварын талаарх худал амлалтын тухай</p> <p>Иргэд, аж ахуйн нэгжид үзүүлж буй татварын дарамтыг бууруулах чиглэлд хэрхэн анхаарч байгаа вэ?</p> <p>Татварын багц хуулийн шинэчлэлийг хийж байгаа боловч уг хуулиудад сүүлийн 10 жилийн хугацаанд 45 орчим нэмэлт, өөрчлөлт, 30 гаруй төрлийн татвар нэмсэн, шинээр бий болгосон өөрчлөлтүүдийг хийсэн байна.</p> <p>Үе үеийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт татварын дарамтыг бууруулж иргэд, аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжих тухай тусгаж голчлон нэр дэвшигч, намууд ярьдаг. Гэвч бодит нөхцөл байдал дээрээ дээр дурдсан 30 гаруй төрлийн татварыг нэмж, шинээр бий болгосон.</p> <p>Сүүлийн 10 жилийн хугацаанд Ерөнхий сайд таны даргалж буй нам засгийн эрхийг дангаар барьж байгаа боловч мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж татварын дарамтыг бууруулаагүй. Иймээс таны тэргүүлж буй Засгийн газрын өргөн барьсан Татварын багц хуулийн шинэчлэлд хэдэн төрлийн татварыг байхгүй болгож, хөнгөлж байгаа вэ?</p> <p>Дээрх асуудлыг шийдвэрлэх талаар Засгийн газарт бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэх арга хэмжээ зорилт үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа эсэх талаар мэдээллийг Монгол Улсын Их Хурлын чуулганд танилцуулж, мөн бичгээр хариу ирүүлж өгөхийг хүсье.</p>

10	С.Эрдэнэболд	<p>Асуулт: Засгийн газар "данхар төрийг цомхотгож, татварын ачааллыг бууруулна" гэж мэдэгдэж байгаа боловч бодит амьдрал дээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд татвар, шимтгэл, төлбөр, хураамжийн дарамт буурсан гэж огт мэдрэхгүй байна. Иймд 2026 онд Засгийн газар төрийн данхар бүтэц, орон тоо, төрийн өмчит компани, төсвийн урсгал зардлыг хэдий хэмжээгээр бодитоор бууруулж, үүний үр дүнд иргэн, аж ахуйн нэгжийн татварын нийт ачааллыг ямар тодорхой үзүүлэлтээр, хэдэн хувиар бууруулах вэ?</p> <p>Үндэслэл, тайлбар: Ер нь "төр данхар том хэвээр байхад татварын дарамт буурах боломжгүй" юм. Засгийн газар 2026 оны төсвийг танилцуулахдаа урсгал зардлыг бууруулах, төрийн өмчит компаниудын тоог 109-өөс 87 болгох, төрийн албан хаагчдын тоог 230.0 мянгаас 218.0 мянга болгох зорилт дэвшүүлсэн байна. Мөн багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах бодлогын арга хэмжээ төсвийн баримт бичгүүдэд тусгагдсан байдаг. Гэвч энэ зорилт бодитой биелэгдэхгүй байгаа тул хувийн хэвшил, аж ахуйн нэгж, хөдөлмөр эрхлэгч иргэдийн нуруун дээрх татвар, шимтгэл, төлбөр, хураамжийн дарамт хэвээр үргэлжилж, "данхар төр" нь өөрөө "дарамтад татвар"-ын үндсэн шалтгаан болж байна.</p> <p>Иймд ерөнхий амлалт бус, тоогоор хэмжигдэхүйц, хугацаатай, хариуцлагатай хариулт өгнө үү. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Төрийн албан хаагчдын тоо, давхардсан чиг үүрэг, агентлаг, төрийн өмчит компанийн тоог бодитоор хэдээр бууруулах вэ?</li> <li>2.Буурсан зардлын хэдэн төгрөгийг татвар, шимтгэл, төлбөр, хураамжийн дарамтыг бууруулахад чиглүүлэх вэ?</li> <li>3.Татварын дарамт буурсан эсэхийг иргэн, аж ахуйн нэгжийн түвшинд ямар үзүүлэлтээр хэмжих вэ?</li> </ol>
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛЭГ</b>		
11	Х.Баасанжаргал	<p>Асуултын хүрээ: Хууль тогтоомжийн биелэлт</p> <p>"Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжүүдийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 160 дугаар тогтоолоор баталсан. Уг тогтоолын 4-т "Төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, дараа оны 02 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд танилцуулж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай." гэж заасан байдаг. Энэ тогтоолын хэрэгжилт хаана яваа вэ? Тогтоолд заасан хугацаа өнгөрсөн байна. Үүнийг хэрэгжүүлэхийг шаардаж байна. Бид олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байна, цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай байгаагаа Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн анхааралд оруулж хөгжлийн бэрхшээлийн</p>

		<p>ойлголтыг нэгтгэх маш том боломж, үүрэг гэж харж байна.</p> <p>Асуултын хүрээ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>1.ЗГҮАХ-н 2.1.1.12-т “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг баталж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ” гэж тусгасан. Энэ хүрээнд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ямар бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа вэ?, Үндэсний төлөвлөгөө батлах үйл явц аль шатандаа байна вэ?</p> <p>2.Хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх нэг чухал арга хэмжээ бол хичээлээс гадуурх үйл ажиллагаа байдаг. Тэгвэл ЗГҮАХ-н 2.1.1.10-т “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ? Таны санаачлан хэрэгжүүлж буй “Чөлөөлье” аяны хүрээнд сургуулийн спорт заалыг сурагчдад үнэ төлбөргүй ашиглуулах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл гэсэн саналыг тавьж байна.</p> <p>3. ЗГҮАХ-н 3.2.1.3-т “Жижиг, дунд болон гарааны бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэгийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулна” гэж, 3.2.2.8-д “Татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагааг татвар төлөгчийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшнээс хамаарч уян хатан зохицуулдаг болж, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжинэ.” гэж тус тус тусгасан. Энэ хүрээнд татварын өрөөс болж дансаа хаалгасан бизнес эрхлэгч, ААНБ-ын дансыг 1 сарын хугацаатай нээсэн. Энэ арга хэмжээний хүрээнд гарсан ахиц, цаашид авч хэрэгжүүлэх урт хугацаанд ямар бодлого баримталж ажиллах вэ?</p> <p>Асуултын хариуг бичгээр авна.</p>
12	О.Номинчимэг	<p>Асуултын хүрээ: Хууль тогтоомжийн биелэлт</p> <p>1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолоор Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбооны хооронд байгуулсан худалдааны түр хэлэлцээрийг соёрхон баталсантай холбогдуулан тамхины гаалийн тарифыг нөхөх, тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх тооцооллыг хийж, холбогдох хууль тогтоомжийн төслийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдаж, хэрэгжиж эхлэх хүртэлх хугацаанд тамхи, тамхин бүтээгдэхүүн, электрон тамхины импортын хэмжээг 2024 оны сар болгоны хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар хязгаарлахыг Засгийн газарт тус тус даалгасан. Сангийн сайдаас дээрх тогтоолын хэрэгжилтийн талаар албан бичгээр тодруулахад одоогоор тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй талаар хариу ирүүлсэн.</p>

		<p>Иймд дээрх тогтоолын хэрэгжилтийг Засгийн газар цаашид хэрхэн хангаж ажиллах вэ? Холбогдох арга хэмжээг ямар хугацаанд авч хэрэгжүүлэх вэ?</p> <p>2. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн "Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 61 дүгээр тогтоолоор "хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1.1</sup>, 27<sup>1.2</sup> дахь хэсэгт нийцүүлэх зорилгоор судалгаа хийж, холбогдох хуулийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх"-ийг Засгийн газарт үүрэг болгосон.</p> <p>Уг тогтоолын хэрэгжилтийн явц ямар түвшинд байна вэ? Энэ хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бэ?</p> <p>Асуултын хариуг бичгээр авна.</p>
13	О.Саранчулуун	<p>Асуултын хүрээ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>2.1.1.21.Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ. Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээний талаар мэдээлэл өгнө үү?</p> <p>2.2.1.16.Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны хүртээмж, орчин, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүний эрхэд ээлтэй дотуур байрыг бий болгоно. Саадгүй орчин, хүртээмжийг хэрхэн хангаж байгаа тухай мэдээлэл өгнө үү?</p> <p>2.2.1.19.Боловсролыг дэмжих сангийн эрх зүйн орчныг шинэчилж, сангийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, тайлан, боловсролын тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг ил тод болгон цахимжуулж, хяналтыг тогтмолжуулна. 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан "Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжих чиглэлээрх үйл ажиллагааг хуваалцана уу?</p> <p>Боловсролын зээлийн санд эрэлттэй мэргэжилд протез-ортозийн эмч мэргэжлийг оруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөө ажиллах мэргэжлээр зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүн эрүүл хүн магистр, докторын сургалтад хамрагдах боломжийг олгоход дэмжлэг үзүүлэх боломжтой юу?</p> <p>Асуултын хүрээ: Тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт</p> <p>2026 онд хэдэн газарт барилгын их засвар хийхээр төлөвлөсөн бэ?</p> <p>Их засварыг хийхдээ саадгүй орчин бүрдүүлэх, хүртээмжийг</p>

		<p>хангахад стандартыг хэрхэн баримталсан бэ?</p> <p>Засвар хийсэн газруудад хүртээмжийн үнэлгээ хийхийг хүсэж байна. Зохион байгуулж өгнө үү?</p> <p>Асуултын хариуг бичгээр авна.</p>
14	Д.Энхтүвшин	<p>Асуултын хүрээ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улс орны эдийн засаг, нийгэм</p> <p>Манай улсын хувьд хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин хангалтгүй байгаагийн зэрэгцээ ажиллах хүчний хомсдол жил ирэх тусам нэмэгдэж байна. Нөгөөтэйгүүр, ажлын байр нэмэгдүүлэх шаардлагатай байна.</p> <p>Ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн салбараар буюу барилгын салбар, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуйн зэрэг эдийн засгийн салбараар авч үзэн тусдаа бодлого боловсруулах шаардлагатай гэж үзэж байгаа.</p> <p>Тодруулбал, Хөдөлмөрийн тухай хуульд уул уурхай олборлох үйлдвэрийн салбарт уртын ээлжтэй холбоотой 14 хоног ажиллаж 14 хоног амрах хатуу зохицуулалт нь тухайн салбарт ажиллах хүчний хомсдол үүсгэдэг.</p> <p>Түүнчлэн барилгын салбар хамгийн их ажиллах хүчний хомсдолтой байдаг. Мөн аялал жуулчлалын салбар зуны улиралд тогооч, үйлчлэгч зэрэг хомсдол үүсдэг. Энэ асуудал дээр гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг бууруулах зэрэг ААН-үүдийг эдийн засгийн салбар бүрээр дэмжих ямар бодлого баримтлах вэ?</p> <p>Оюутан залуучууд, тэтгэвэрт гарсан ахмадуудыг хөдөлмөрийн зах зээлд оролцуулах талаар Засгийн газраас арга хэмжээ авч ажиллах уу? Өнгөрсөн сард энэ асуултыг асуусан боломжит хувилбаруудыг судалж үзсэн үү?</p>
<b>ХҮН НАМЫН ЗӨВЛӨЛ</b>		
15	Б.Мөнхсоёл	<p>Асуулт 1.Төсвийн бодлогын шинэчлэлийн хүрээнд: ҮСХ-ноос гаргасан мөнгөний статистикийн мэдээллийн дагуу 2026 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээрх улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 8.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 459.7 их наяд төгрөгөөр өсөж, төсвийн нийт зарлага, эргэн төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 10.4 их наяд төгрөг болж, улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарчээ. ДНБ-д төсвийн нийт зардлыг эзлэх хувь 2024 онд 38,3%, 2025 онд 35% байсан бол 2026 оны 4-р сарын урьдчилсан гүйцэтгэлээрх 45 хувь болтол нэмэгдсэн байна. Монголбанкны судалгаагаар төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийн 1%-ийн өсөлт нь 2-р улирлын дараагаас импортыг 0.2-0.4%-иар нэмэгдүүлдэг. ҮАГ-ын тайланд 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний 57.3% нь үр дүнгүй байж, нийт санхүүжилтийн зөвхөн 37.9% гүйцэтгэгдсэн. ТТБЗ-өөс Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд "Санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй, хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн тооцоо бүрэн хийгдээгүй</p>

		<p>байна" гэж дүгнэлт өгсөн. Нөхцөл байдал ийм байхад Засгийн газраас хэзээ төсвийн бодлогод зоригтой шинэчлэл хийн эдийн засаг дахь төрийн оролцоог хэрхэн ЧӨЛӨӨЛӨХ вэ? Эдийн засаг дахь хувийн хэвшлийн орон зайг нэмэгдүүлж, мөчлөг сөрсөн төсвийн бодлогын төлөвлөгөөг хэзээ танилцуулах вэ?</p> <p>Асуулт 2.Инфляцыг бууруулах бодлогын хүрээнд:</p> <p>ҮСХ-ноос гаргасан мөнгөний статистикийн мэдээллийн дагуу 2026 оны 1-р улирлын мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 25.3% өсжээ. Тухайлбал мөнгөний нийлүүлэлт 2026 оны 4-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 51.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.3 их наядаар өссөн байна. Мөн 2026 оны 4-р сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар, өмнөх сараас 2.8 хувиар өссөн байна. Зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрч, нарийвчилсан тооцоо, судалгаа хийхгүйгээр томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, төсвийн зохисгүй бодлогын нөлөөгөөр инфляцын түвшин зорилтот түвшнээс хэтэрч оны эцэс хүртэл дахин нэмэгдэх эрсдэлтэй нөхцөл байдлын үед Засгийн газраас инфляцыг бууруулах, бага, дунд орлоготой иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр ямар дорвитой арга хэмжээ авч ЧӨЛӨӨЛӨХ вэ?</p> <p>3.Орон сууцны хангамж, хүртээмжийг сайжруулах бодлогын хүрээнд:</p> <p>2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан 13 томоохон төслийн нийт санхүүжилт 65.5 их наяд төгрөгт хүрч, тухайн жилд шаардагдах санхүүжилт 15.3 их наяд болж байна. Нийслэл Улаанбаатар хотод орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2026-2028 онуудад хэрэгжүүлж буй орон сууцны төслүүдийг нэгтгэн дүгнэвэл 27,267 өрхийн орон сууцны барилга ашиглалтад орох нь. Гэтэл 2025 онд Улаанбаатар хотод 20,527 өрхийн орон сууцны барилга ашиглалтад орсон байна. Эндээс УБ хот дахь орон сууцны барилгын зах зээлийн төрийн оролцоог ямар байгааг харж болно. Эдгээр төслүүдийг төсвөөс шууд санхүүжүүлэхээс татгалзаж, гадаадын хөрөнгө оруулалт, дотоодын хувийн хөрөнгө оруулалт, ТХХ-ийн түншлэл зэрэг олон эх үүсвэрийн тэнцвэртэй хослолыг хангахгүй бол ирэх онуудад Улаанбаатар хотын орон сууцны үнэ 15-25% өсөх бодит эрсдэл байна. Өнгөрсөн сарын Засгийн газрын асуулгын цагаар асуусан бага, дунд орлоготой иргэдийн орон сууцаар хангах ипотекийн зээлийн тогтолцоог хэзээ шинэчлэх вэ? Монгол хүний ая тухтай орон сууцанд амьдрах хэрэгцээг хангах төрийн бодлогын хүрээнд хэрхэн ЧӨЛӨӨЛӨХ вэ?</p>
<b>ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ</b>		
16	Б.Батбаатар	<p>1.Ерөнхий сайд аа, Та томилогдоод 60 хоног болж байна. Энэ хугацаанд иргэдийн амьдралд бодитоор мэдэгдсэн ямар өөрчлөлт гарсан бэ?</p> <p>2.Өнөөдөр иргэдийн хамгийн их ярьж байгаа асуудал бол үнэ, орлого, орон сууц, ажлын байр, түгжрэл хэвээр байна.</p>

		<p>Тиймээс таны Засгийн газрын эхний 60 хоногийн бодит үр дүнг 3 тоон үзүүлэлтээр хэлж өгнө үү?</p> <p>3.Мөн 100 хоног хүрэхэд, өөрөөр хэлбэл дараагийн 40 хоногт Монгол Улс 2026 оныг давах эдийн засаг, төсөв, нийгмийн бэлтгэлээ хангаж чадах уу?</p> <p>4.Хэрэв чадах бол ямар 3 хэмжигдэхүйц үр дүнгээр батлах вэ? Хэрэв чадахгүй бол улс төрийн болон бодлогын ямар хариуцлага хүлээх вэ?</p>
17	М.Нарантуяа-Нара	<p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцэн баталсан Үнийн өсөлтийн эсрэг авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол, түүний хэрэгжилтийн талаар дараах асуултыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1.Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын явц, үр дүнгийн талаар;</p> <p>2.Малчдаас хэрэглэгч хүртэлх нийлүүлэлтийн сүлжээ, дамжлагын үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын талаар;</p> <p>3.Нөөцийн мах бэлтгэл, нийлүүлэлт, түгээлтийн бодлого, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;</p> <p>4.Дээрх тогтоолын хэрэгжилтийн үр дүнд махны үнийг тогтворжуулах чиглэлээр богино, дунд хугацаанд хүлээгдэж буй үр дүнгийн талаар;</p> <p>5.Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийг бууруулах, тогтвортой байлгах, хомслоос сэргийлэх талаар цаашид авч хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөө зэрэг болно.</p>